



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР 2019 ОН



Өлгий хот 2020 он

Танилцуулгыг хянан, тохиосон:

Н.Ерлан

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Н.Манаргүл

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

E-mail: bayan-ulgii@nso.mn

Утас: 70422322

Интернет хаяг: [//www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/](http://www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Өлгий хот, 2020 оны 6-р сар

АГУУЛГА

I. Оршил	4
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	5-6
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	7-8
II. Мал аж ахуй	
II.2.1 Малчдын тоо насны бүтэц	8
II.2.2 Малтай өрх, малчин өрх, малчдын тоо	9
II.2.3 Малчдын соёл, ахуйн үзүүлэлт	10
II.2.4 Малын тоо, сүргийн бүтэц	10-13
II.2.5 Хээлтэгчийн тоо, хээл хаялт, сувайралт	14-15
II.2.6 Малын хэрэглээний зарлага	16
II.2.7 Төл бойжилт	16-18
II.2.8 Том малын зүй бус хорогдол	18-19
II.2.9 Иргэдийн хувийн малын бүлэглэлт	19-20
III. Хадлан бэлтгэл, тариалсан талбай, хураасан ургац	
II.2.10 Бэлтгэсэн хадлан	20
II.2.11 Тариалсан талбай, хураасан ургац	21
II.2.12 Хөдөө аж ахуйн эдэлбэр газар	22
VI. Дүгнэлт	23-24

ОРШИЛ

ХАА-н салбар нь манай улс орны эдийн засгийн баталгаа болж байдаг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2019 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2019 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2019 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна аймгийн хэмжээний тариалсан талбай, хураасан ургац, бэлтгэсэн хадлан, тэжээлийн мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр –	1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ -	5 хонь
1 адуу -	7 хонь
1 үхэр -	6 хонь
1 хонь -	1 хонь
1 ямаа -	0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ –	4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу –	3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр –	2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал –	тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл,	2, 3 настай
Адуу-	Өмнөх оны төл, 2 настай
Үхэр-	Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25, Азарга - 12-15, Бух - 35-45,
Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол,

гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22,

Үр тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
- 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
- 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
- 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.


ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2019 оны жилийн эцэст 8703 малчин өрх, 13746 малчин, толгойн тоогоор 2 сая 192 мянга 764, бодод шилжүүлснээр 549.1 мянган толгой, үүнээс тэмээ 5913, адуу 99020, үхэр 158582, хонь 995904, ямаа 933345 тоологдсон. Нийт малын 12 хувийг бод, 88. хувийг бог мал эзэлж байна. Оны эхний төллөх насны хээлтэгчийн 94.9 хувь төллөж, 809.2 мянган төл бойжиж, төл бойжилт 93.2 хувь байна. 60425 толгой том мал зүй бусаар хорогдож, оны эхний малын 2.8 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд үр тариа 24.0 тн, төмс 3535 тн, хүнсний ногоо 1630.5 тн хураасан нь өнгөрсөн оноос төмс 529.8 тн-оор, хүнсний ногоо 106.4 тн-оор их байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбар 37.5 хувийг эзлэж 152.7 тэрбум төгрөг хүрсэн байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ

үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019*	/тэрбум төгрөг/	
						2019/2018 хувь	зөрүү
Бүгд	311	307	329.5	343.3	407.2	118.6	63.9
ХАА	126.6	116	116.3	116	152.7	131.6	36.7
ДНБ-д эзлэх хувь	40.2	38.9	35.3	38.5	37.5	97.4	-1.0

ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ /тэрбум.төг/



Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотроо мал аж ахуйн салбарын аймгийн ДНБ-ий 37.5 хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өсөж байна.


Улсын хэмжээнд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах хандлагатай байна. ХАА-н салбар нь 2015 онд ДНБ-ний 40.2 хувийг эзэлж байсан бол 2019 онд 37.5 хувийг эзэлж байна. Баруун бүсийн дүнд эзлэх хувь 2001-2007 онд өсөж 74.2-т хүрч 2016 онд 41.2 хувь болон буурсан ч 2018 онд 1.7 пунктээр нэмэгдэж 2019 онд 0.8 пунктээр дахин буурсан байна. Баян-Өлгий аймгийн хувьд хандлага нь баруун бүсийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 2004 онд 67.2 хувийг эзэлдэг байсан бол, манай улсын эдийн засгийн цар хүрээ тэлж, үйлчилгээ, аж үйлдвэр, барилгын салбар эрчимтэй хөгжсөнөөр хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь аажмаар буурч 2019 онд 37.5 хувийг эзэлж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



Аймгийн хэмжээгээр 2019 онд мал тооллогын дүнгээр 8703 малчин өрх, 13746 малчин тоологдсон байна. Үүнээс 16-34 насны малчдын тоо 4569, 35-59 насных 8168, 60-аас дээш насны малчдын тоо 1009 хүн байгаа нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин байна.

МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮТЦЭЭР, 2019 ОН



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

Сум	Нийт малчдын тоо	15-34 насны малчид	35-59 насны малчид	60+ настай малчид	Хувиар			Нийт малчдаас эрэгтэй	Нийт малчдаас эмэгтэй
					15-34	35-59	60+		
Өлгий	8	5	1	2	62.5	12.5	25	7	1
Алтай	940	282	571	87	30	60.7	9.3	618	322
Алтанцөгц	556	172	348	36	30.9	62.6	6.5	388	168
Баяннуур	629	158	426	45	25.1	67.7	7.2	520	109
Бугат	468	161	282	25	34.4	60.3	5.3	316	152
Булган	1 483	592	817	74	39.9	55.1	5	836	647
Буянт	720	232	422	66	32.2	58.6	9.2	406	314
Дэлүүн	1 563	530	1001	32	33.9	64	2	866	697
Ногооннуур	1 184	406	702	76	34.3	59.3	6.4	846	338
Сагсай	920	317	506	97	34.5	55	10.5	674	246
Толбо	883	272	509	102	30.8	57.6	11.6	610	273
Улаанхус	1 958	603	1219	136	30.8	62.3	6.9	1130	828
Цэнгэл	2 434	839	1364	231	34.5	56	9.5	1562	872
Дүн	13 746	4 569	8168	1009	33.2	59.4	7.3	8779	4967

МАЛТАЙ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН НАСНЫ БҮЛЭГЭЭР

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018	2019
Малтай өрх	14610	14960	14976	14910	14948
Малчин өрх	8872	8888	9261	8728	8703
Малчдын тоо	18398	18411	17200	13993	13746
Үүнээс: 15-34 насны	7396	6927	6515	4979	4569
35-59 насны	9433	9884	8823	7553	8168
Тэтгэврийн насны	1569	1600	1862	1461	1009

МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО, СУМААР

Сумын нэр	Малтай өрхийн тоо				Малчин өрхийн тоо			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
Алтай	1 009	1 000	982	975	697	76	657	639
Алтанцөгц	677	683	691	692	347	702	342	368
Баяннуур	1 010	1 028	1 016	1 010	527	383	438	539
Бугат	748	796	791	782	427	454	351	336
Булган	1 154	1 169	1 175	1 219	727	427	757	761
Буянт	659	660	661	647	467	782	384	389
Дэлүүн	1 407	1 423	1 404	1 384	978	439	939	861
Ногооннуур	1 492	1 529	1 550	1 560	796	1 036	849	852
Сагсай	1 107	1 135	1 136	1 118	615	904	719	683
Толбо	863	870	898	876	607	793	645	620
Улаанхус	1 588	1 557	1 561	1 586	1 259	589	1 184	1 119
Цэнгэл	1 716	1 720	1 712	1 707	1 439	1 207	1 459	1 532
Өлгий	1 531	1 406	1 333	1 392	2	1 469	4	4
Дүн	14961	14976	14910	14948	8888	9261	8728	8703

МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХИЙН ТООГООР

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018	2019
Цахилгаантай өрх	7289	5928	5978	6363	6109
Телевизортой	4355	3401	3554	3211	3669
Автомашинтай	3542	5359	2301	3248	3531
Мотоциклтэй	3475	2775	1730	2541	3476
Худагтай	2974	3691	5240	4372	4898

2019 оны тооллогоор нийт малчин өрхийн 70.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 42.2 хувь нь телевизортой, 40.6 хувь нь авто машинтай, 39.9 хувь нь мотоциклтэй, 56.3 хувь нь инженерийн хийцтэй худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хэрэглээг өрхийн тоо өнөрсөн жилээс буурсан байна. 2008 онд 6.2 мянган өрх цахилгааны эх үүсгүүртэй байсан бол 2009 онд 9.2 мянга болж 1.5 дахин буюу 2.9 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Харин 2018 онд энэ үзүүлэлт 6.3 мянга болж 31.5 хувиар багассан нь сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар 2019 онд цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 6.1 мянга болж 4 хувиар буурсан байна. 2019 онд авто машинтай өрхийн тоо 283 өрхөөр буюу 8.7 хувиар, Мотоциклтэй өрхийн тоо 935 өрхөөр буюу 36.8 хувиар тус тус нэмэгдэж байна.

МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СУМААР, 2019 ОН

Сум	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Гар угастай		Хийсэн эсгий (м)
		Өрхийн тоо	Машины тоо	Өрхийн тоо	Мотоцикл ийн тоо	Өрхийн тоо	Гар угасны тоо	
Алтай	269	232	267	133	133	746	746	75
Алтанцөгц	323	187	212	159	159	442	442	8
Баяннуур	914	92	115	100	101	568	568	194
Бугат	461	339	390	197	197	391	391	336
Булган	349	262	284	391	393	1 047	1 047	602
Буянт	38	154	184	232	233	520	520	40
Дэлүүн	2	496	550	421	425	1 063	1 063	402
Ногооннуур	584	522	607	610	615	974	974	10
Сагсай	335	214	248	210	214	783	783	123
Толбо	279	211	241	128	128	705	705	16
Улаанхус	544	482	559	757	769	1 416	1 416	865
Цэнгэл	588	236	276	137	138	1 912	1 912	981
Өлгий	212	104	117	1	1	5	5	
Дүн	4898	3531	4050	3476	3506	10572	10572	3652

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2192.8 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 1.2 хувиар буюу 25847 толгойгоор өслөө. Үүнд тэмээ 5913 толгой, адуу 99020 толгой, үхэр 158582 толгой, хонь 995904 толгой, ямаа 933345 толгой тус тус тоологдлоо.

МАЛЫН ТОО, ТАВАН ТӨРЛӨӨР, 2019 ОН

Сум	Толгойн тоогоор					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өлгий	27 091	33	1 492	6 065	6 890	12 611
Алтай	154 714	359	9 503	15 485	81 541	47 826
Алтанцөгц	134 258	1 102	5 923	6 809	51 746	68 678
Баяннуур	161 224	582	6 305	6 652	56 435	91 250
Бугат	119 690	86	5 047	7 671	53 255	53 631
Булган	130 311	615	7 390	12 725	28 286	81 295
Буянт	131 898	204	4 993	9 452	79 878	37 371
Дэлүүн	228 875	327	10 746	20 568	97 945	99 289
Ногооннуур	241 843	636	10 497	13 558	93 779	123 373
Сагсай	158 957	321	8 524	11 610	86 176	52 326
Толбо	170 269	112	6 400	9 498	104 686	49 573
Улаанхус	221 032	806	9 243	18 827	113 740	78 416
Цэнгэл	312 602	730	12 957	19 662	141 547	137 706
Нийт дүн	2 192 764	5 913	99 020	158 582	995 904	933 345


МАЛЫН ТОО, ТАВАН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Бодоор /мян.тол/	487,6	528,6	548,6	539,3	549,1
Толгойн тоо	2021046	2167351	2226149	2166917	2192764
Тэмээ	4717	4933	5279	5649	5913
Адуу	77291	85779	93402	95349	99020
Үхэр	144761	155615	161025	155914	158582
Хонь	850620	937710	995222	979601	995904
Ямаа	943657	983314	971221	930404	933345

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Дүн	44.4	42.2	41.1	42.2	41.6
Ингэ	29.6	30.0	30.0	30.1	30.8
Гүү	32.7	29.7	29.8	31.3	31.6
Үнээ	43.9	38.7	38.8	39.6	40.1
Эм хонь	45.6	48.1	43.7	46.3	42.2
Эх ямаа	44.4	44.3	42.5	43.5	42.4

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2019 ОН




МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР, СУМААР, БОДОД ШИЛЖҮҮЛСЭН, 2019 ОН

Сум	Бодод шилжүүлсэн					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өлгий	10 331.2	49.5	1 492.0	6 065.0	1 148.3	1 576.4
Алтай	45 094.9	538.5	9 503.0	15 485.0	13 590.2	5 978.3
Алтанцөгц	31 594.1	1 653.0	5 923.0	6 809.0	8 624.3	8 584.8
Баяннуур	34 642.1	873.0	6 305.0	6 652.0	9 405.8	11 406.3
Бугат	28 426.7	129.0	5 047.0	7 671.0	8 875.8	6 703.9
Булган	35 913.7	922.5	7 390.0	12 725.0	4 714.3	10 161.9
Буянт	32 735.4	306.0	4 993.0	9 452.0	13 313.0	4 671.4
Дэлүүн	60 539.8	490.5	10 746.0	20 568.0	16 324.2	12 411.1
Ногооннуур	56 060.5	954.0	10 497.0	13 558.0	15 629.8	15 421.6
Сагсай	41 518.9	481.5	8 524.0	11 610.0	14 362.7	6 540.8
Толбо	39 710.3	168.0	6 400.0	9 498.0	17 447.7	6 196.6
Улаанхус	58 037.7	1 209.0	9 243.0	18 827.0	18 956.7	9 802.0
Цэнгэл	74 518.4	1 095.0	12 957.0	19 662.0	23 591.2	17 213.3
Нийт дүн	549 123.6	8 869.5	99 020.0	158 582.0	165 984.0	116 668.1


Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх хонины тоо толгойн хэмжээ буурах хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт мал сүргийн 1991 онд 60.7 хувийг хонь эзэлж байсан бол 1992 оноос буурч 2016 онд 45.4 хувьд хүрчээ. Аймгийн хонины тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь 2001-2019 онд улсын дүнгээс доогуур түвшинд байгаа боловч 2013 оноос баруун бүсийн дүнгээс дээгүүр түвшинд байна.

ХОНИНЫ ТОО ТОЛГОЙН СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгойн хэмжээ 1971-1992 онд тогтвортой байсан бол 1992 оноос огцом өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт сүргийн 1971 онд 26.3 хувийг ямаа эзэлж байсан бол 2019 онд 42.6 хувьд хүрчээ. Ямааны тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь улсын дүнгээс 1.4 пунктээр өндөр байгаа ч баруун бүсийн дүнгээс 4.7 пунктээр бага байна.

ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудын дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Дүн	835766	914198	915932	914738	913068
Ингэ	1384	1482	1571	1695	1821
Гүү	22770	25495	27750	29412	31287
Үнээ	55884	60269	62282	62096	63643
Эм хонь	364523	409189	420942	423590	420465
Эх ямаа	391205	417763	403387	397945	395852

Хээлтэгч мал нь нийт малын 41.6 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.8 хувь, адуун сүргийн 31.6 хувь, үхэр сүргийн 40.1 хувь, хонин сүргийн 42.2 хувь, ямаан сүргийн 42.4 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50 – 55 хувь, бог малын хувьд сүргийн 60 – 65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 34.2 хувь, бог малд 42.3 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Дүн	44.4	42.2	41.1	42.2	41.6
Ингэ	29.6	30.0	30.0	30.1	30.8
Гүү	32.7	29.7	29.8	31.3	31.6
Үнээ	43.9	38.7	38.8	39.6	40.1
Эм хонь	45.6	48.1	43.7	46.3	42.2
Эх ямаа	44.4	44.3	42.5	43.5	42.4

ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Дүн	4369	23945	12137	46258	63035
Ингэ	2	8	2	7	19
Гүү	162	716	381	2140	2063
Үнээ	238	734	598	1374	1547
Эм хонь	1384	3995	1936	6763	9158
Эм ямаа	2583	18492	9220	35974	50248

2019 онд оны эхний төллөх насны хээлтэгчийн 6.9 хувь буюу 63035 толгой мал хээл хаясны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2018 оныхоос 16777 толгойгоор буюу 36.3 хувиар өссөн байна.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Дүн	10304	18095	14706	38856	35826
Ингэ	34	85	43	40	55
Гүү	817	1255	1450	2459	2416
Үнээ	1720	2517	2811	4496	4746
Эм хонь	3454	5946	4647	18361	15304
Эм ямаа	4279	8292	5755	13500	13305

ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Дүн	21265	22947	23376	22215	22467
Буур	77	87	93	114	124
Азарга	2233	2512	2762	2840	3195
Бух	2874	2992	3031	2761	2998
Хуц	7695	8401	9002	8380	8193
Ухна	8386	8955	8488	8120	7957


2019 онд 22467 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2018 оныхоос 1.1 хувиар буюу 252 толгойгоор өссөн байна.

НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НОГДОХ ХЭЭЛТЭГЧИЙН ТОО, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Төрөл	Үржлийн норм	2015	2016	2017	2018	2019
Ингэ	20-25	18	17	16	15	15
Гүү	12--15	10	10	9	10	10
Үнээ	35-45	19	20	20	22	21
Эм хонь	25-30	47	49	45	49	51
Эм ямаа	25-30	47	47	49	41	50

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой бол эм хонь 51, эм ямаа 50 ногдож өндөр үзүүлэлт гарч байна.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГЫН БҮТЭЦ /хувиар/



2019 онд оны эхний малын 36 хувьтай тэнцэх 780665 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Үүнээс 26 хувийг хүнсэнд, 69 орчим хувийг зах зээлд худалдан борлуулж, 4 хувийг шилжүүлж, 1 хувь буюу 3153 толгой мал хулгайд алдагдсан байна.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА, 2019 ОН, ТОЛГОЙГООР

Сум	Зах зээлд худалдаж, борлуулсан	Шилжүүлсэн	Алдсан, хулгайлагдсан, олдохгүй байгаа	Хүнсэнд хэрэглэсэн
Алтай	35284	3393	182	15566
Алтанцөгц	24055	3469	61	10197
Баяннуур	39457	5462	907	12389
Бугат	29753	6466	366	10813
Булган	31748	1510	130	13626
Буянт	31250	1496	111	9911
Дэлүүн	55773	2919	177	22528
Ногооннуур	47757	1428	178	26295
Сагсай	49695	1210	356	17639
Толбо	43928	1124	295	12644
Улаанхус	62215	2939	212	24249
Цэнгэл	78548	1071	138	25781
Өлгий	10735	466	40	2723
Дүн	540198	32953	3153	204361

Төл бойжилт

2019 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 94.9 хувь буюу 867838 толгой эх мал төллөж гарсан төлийн 93.2 хувь буюу 809170 толгой төл бойжуулав.

ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ, 2019 ОН

Сум	Бүгд	Төллөсөн хээлтэгч				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Өлгий	12426	7	428	2589	3383	6019
Алтай	64370	83	2785	6084	35664	19754
Алтанцөгц	49219	230	1362	1824	20073	25730
Баяннуур	62425	93	1097	2405	21873	36957
Бугат	51585	19	1536	2780	23793	23457
Булган	44272	103	2022	4856	12600	24691
Буянт	56926	50	1372	4012	35946	15546
Дэлүүн	91312	70	3265	7929	45200	34848
Ногооннуур	79808	135	2098	3712	33008	40855
Сагсай	84405	69	2926	5198	44944	31268
Толбо	62479	17	1579	3255	39995	17633
Улаанхус	95427	140	2673	7481	51054	34079
Цэнгэл	113184	106	3021	6455	51994	51608
Бүгд	867838	1122	26164	58580	419527	362445

БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР, 5 ТӨРЛӨӨР

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
2004	524505	547	11917	29467	232859	249715
2005	410257	473	9664	24541	203799	171780
2006	521900	508	12240	28166	231710	249076
2007	539265	443	12402	28270	240525	257625
2008	484506	424	9729	23705	234999	215649
2009	413901	487	8656	22460	207360	174938
2010	357520	420	6726	19061	181318	149995
2011	487580	615	11036	26655	204194	245080
2012	489680	642	12575	26600	217323	232540
2013	607272	665	13553	34455	255534	303065
2014	664384	613	15785	41846	288752	317388
2015	781029	726	19625	49506	345737	365435
2016	789819	700	20563	52439	353164	362953
2017	856849	964	23373	56034	394647	381831
2018	749643	1002	22126	54090	357368	315057
2019	809170	1055	24441	56381	399123	328170
%	107.9	105.3	110.5	104.2	111.7	104.2
Өмнөх оноос зөрүү	59527	53	2315	2291	41755	13113

БОЙЖУУЛСАН ТӨЛ, 2019 ОН

Сум	Бүгд	Бойжсон төл				
		Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Өлгий	12181	7	415	2561	3325	5873
Алтай	60735	76	2532	5753	34281	18093
Алтанцөгц	44949	216	1319	1758	18670	22986
Баяннуур	57539	87	990	2291	19893	34278
Бугат	44300	16	1360	2658	20841	19425
Булган	40298	91	1775	4561	11726	22145
Буянт	51972	38	1183	3742	33460	13549
Дэлүүн	84702	65	3126	7717	42108	31686
Ногооннуур	77724	135	2027	3578	32362	39622
Сагсай	82004	65	2865	5082	44356	29636
Толбо	55619	17	1513	3102	37478	13509
Улаанхус	93358	137	2599	7365	50433	32824
Цэнгэл	103789	105	2737	6213	50190	44544
Бүгд	809170	1055	24441	56381	399123	328170

Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад төлийн төрөл дээр 59527 толгой буюу 7.9 хувиар өссөн байгааг дээрх хүснэгтээс харж болно.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2019 онд оны эхний нийт малын 2.8 хувьтай тэнцэх буюу 60425 толгой мал хорогдсон нь 2018 оныхоос 10624 толгойгоор буюу 15 хувиар бага байна. Нийт хорогдсон малын 44.4 хувийг ямаа, 38.4 хувийг хонь, 12.1 хувийг үхэр, 5 хувийг адуу, 0.1 хувийг тэмээ эзэлнэ. Өвчнөөр 3007 толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 5 хувийг эзэлж байна.

Сум	Хорогдсон том мал, бүгд				
	2015	2016	2017	2018	2019
Өлгий	247	386	311	1237	612
Алтай	488	2663	761	5669	2192
Алтанцөгц	379	936	577	2717	1626
Баяннуур	700	2267	533	14325	8025
Бугат	185	288	149	2249	2011
Булган	517	1544	9409	1085	7387
Буянт	293	450	729	13057	2336
Дэлүүн	685	963	887	11214	13917
Ногооннуур	503	1071	331	1653	2406
Сагсай	538	1721	1930	8741	3882
Толбо	94	526	543	2554	7076
Улаанхус	324	549	366	4091	3375
Цэнгэл	566	17489	1274	2457	5580
Дүн	5519	30853	17800	71049	60425

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР, АЙМГИЙН ДҮНГЭЭР

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Бүгд	5519	30873	17800	71049	60425
Тэмээ	35	55	34	54	63
Адуу	440	1338	800	2896	3025
Үхэр	735	3167	1718	7491	7308
Хонь	1808	10260	4594	27696	23173
Ямаа	2501	16053	10654	32912	26856

ОНЫ ЭХНИЙ МАЛД ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Бүгд	0.3	1.5	0.8	3.3	2.8
Тэмээ	0.7	1.1	0.7	1	1.1
Адуу	0.6	1.8	0.9	3	3.1
Үхэр	0.6	2.2	1.1	4.8	4.6
Хонь	0.2	1.2	0.5	2.8	2.3
Ямаа	0.3	1.8	1.1	3.5	2.9

ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, СҮҮЛИЙН 3 ЖИЛЭЭР

Үзүүлэлтүүд	Малтай өрхийн тоо			Малын тоо		
	2017	2018	2019	2017	2018	2019
10 хүртэл малтай	2 042	2 077	2 134	9 029	9 199	9 448
11-30 малтай	1 793	1 868	1 967	36 045	37 024	39 328
31-50 малтай	1 300	1 331	1 257	51 913	53 310	49 928
51-100 малтай	2 235	2 233	2 100	166 129	166 844	156 150
101-200 малтай	3 965	3 948	4 033	579 083	574 004	583 327
201-500 малтай	3 044	2 905	2 843	890 528	854 098	832 284
501-999 малтай	489	427	475	320 485	283 756	311 548
1000-1499 малтай	61	77	89	71 375	92 112	104 952
1500-2000 малтай	24	22	32	40 297	37 699	55 704
2000 дээш малтай	23	22	18	58 276	55 724	47 687
Дүн	14976	14 910	14 948	2223160	2 163 770	2 190 356

НЭГ ӨРХӨД НОГДОХ ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Бүлэглэлт	Өрхийн тоо	Малын тоо	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Нэг өрхөд ногдох малын тоо, бодод шилжүүлсэн ээр	Нэг өрхөд ногдох малын тоо
10 хүртэлх	2 134	9 448	0	547	5 921	752	2 228	3.2	4.4
11-30	1 967	39 328	49	2 405	6 323	11 731	18 820	6.7	20.0
31-50	1 257	49 928	109	3 037	5 854	17 213	23 715	11.8	39.7
51-100	2 100	156 150	221	8 450	14 981	62 064	70 434	20.4	74.4
101-200	4 033	583 327	1 002	25 387	41 638	247 028	268 272	35.5	144.6
201-500	2 843	832 284	2 284	35 846	52 784	379 402	361 968	70.5	292.7
501-999	475	311 548	1 442	13 889	18 742	160 065	117 410	160.3	655.9
1000-1499	89	104 952	473	4 559	6 681	56 750	36 489	291.8	1 179.2
1500-2000	32	55 704	243	2 505	3 383	31 888	17 685	430.6	1 740.8
2001-с дээш	18	47 687	90	1 700	2 090	28 020	15 787	587.1	2 649.3
Дүн	14 948	2 190 356	5 913	98 325	158 397	994 913	932 808	36.7	146.5

Мал бүхий 14948 өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл, 14.3 хувь буюу 2134 өрх нь 10 хүртэл малтай; 13.2 хувь нь буюу 1967 өрх нь 11-30 малтай; 8.4 хувь буюу 1257 нь 31-50 малтай; 14 хувь буюу 2100 нь 51-100 малтай; 27 хувь буюу 4033 нь 101-200 малтай; 19 хувь буюу 2843 нь 201-500 малтай; 3.2 хувь буюу 475 нь 501-999 малтай; 0.6 хувь буюу 89 нь 1000-1499; 0.2 хувь буюу 32 нь 1500-2000 малтай; 0.1 хувь буюу 18 өрх 2000 аас дээш малтай өрх байна.

Мөн 2019 онд нийт малтай өрхөд 31-100 хүртэлх толгой малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.5-1 пунктээр буурч, 10-30 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 0.4-0.3.7 пунктээр, 101-200 малтай өрх 0.5 пунктээр, 501-2000 малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.1-0.3 пунктээр тус тус нэмэгдсэн дүн гарчээ.

БЭЛТГЭСЭН ХАДЛАН, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Сум	2015	2016	2017	2018	2019
Алтай	5320	3817	5514	5596	6259.5
Алтанцөгц	3510	5500	3040	3854	5131
Баяннуур	5700	3729	5897	6357.5	7760.1
Бугат	2250	6000	2563	1512	3556
Булган	3800	2711	4046.8	4289.5	4261
Буянт	2380	3902	1766	1849.3	2336.7
Дэлүүн	2413	2522.5	2593	3347.4	3903.7
Ногооннуур	13175	3010.1	11963.8	15590	21365
Сагсай	4014	16257.8	4117	4257	5069
Толбо	3000	5566	2597	2799.6	2698
Улаанхус	3300	3134	3935.8	4278.1	4585.2
Цэнгэл	7970	4445	6730.9	8443	9673
Өлгий	2400	6827	2293.6	1919.7	4912.5
Дүн	59232	67421	57059	64093.1	81510.7

БЭЛТГЭСЭН ӨВС, ТЭЖЭЭЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Бүгд	60301	68824	57615	64101.6	82840.7
Байгалийн хадлан	59232	67422	57059	64093.1	81510.7
Таримал тэжээл	1069	1401.6	556	8.5	1330

Бэлтгэсэн хадлан, таримал тэжээлийг нэр төрлөөр өмнөх оныхтой харьцуулан авч үзвэл бэлтгэсэн байгалийн хадлан 29.2 хувь буюу 18739 тонноор, таримал тэжээл 1321.5 тонноор нэмэгдсэн байна.

Тариалсан талбай

Баян-Өлгий аймагт 1990 онд 5.1 мянган га талбайд тариалан эрхэлж байсан бол 2019 онд 1.1 мянган га талбай болж өссөн байна. Нийт талбайн 58.9 хувь буюу 668.9 га талбайд малын тэжээлийн ургамал, 26.9 хувь буюу 305.4 га талбайд төмс, 12.4 хувь буюу 141.3 га-д хүнсний ногоо, 1.7 хувь буюу 18.9 га талбайд үр тариа тариалжээ. Энэ нь өнгөрсөн оныхоос үр тариа 23.1 га-гаар, хүнсний ногоо 154.8 га-гаар, 60.5 га-гаар малын таримал тэжээл 528.5 га-гаар тус тус буурсан байна.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР /га/

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Нийт тариалсан талбай:	907.7	885.4	1106.3	1901.4	1134.5
Үр тариа	47.5	45.5	25.5	42	18.9
Төмс	282	262	485.1	365.9	305.4
Хүнсний ногоо	123	123	161.5	296.1	141.3
Тэжээлийн ургамал	455	455	434.2	1197.4	668.9

Хураасан ургац

Баян-Өлгий аймаг 1990 онд 80.0 мян.т тэжээлийн ургамал, 6.3 мян.т төмс, 1.5 мян.т хүнсний ногоо, 14.1 тонн үр тариа хурааж байсан бол 2019 онд 3.5 мян.т төмс, 1.6 мян.т хүнсний ногоо, 1.3 мян.т тэжээлийн ургамал, 24 тн үр тариа хураан авчээ.

2019 онд хураасан ургац 2017 оныхоос үр тариа 20 тонн буюу 45.5 хувиар бага байгаа бол, төмс 529.8 тонн буюу 17.6 хувиар, хүнсний ногоо 106.4 тонн буюу 7 хувиар, тэжээлийн ургамал 551.5 тонн буюу 70.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ХУРААСАН УРГАЦ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР /тн/

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Үр тариа	56.9	56	46.1	44	24
Төмс	2756	2728	3254.6	3005.2	3535
Хүнсний ногоо	1118	1137	1612.3	1524.1	1630.5
Тэжээлийн ургамал	1069	1402	792.1	778.5	1330

Хөдөө аж ахуйн эдэлбэр газар

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээгээр 2019 онд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 3509.7 мянган га байна. Үүний 99.6 хувийг бэлчээрийн талбай, 0.3 хувийг хадлангийн талбай, 0.03 хувийг тариалангийн талбай, 0.01 хувийг атаршсан газар, 0.02 хувийг бусад хэрэгцээний газар эзэлж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, ГА-ГААР

Сум	ХАА-н эдэлбэр газар Бүгд	Үүнээс:				ХАА-н бусад хэрэгцээний газар
		Бэлчээрийн газар	Хадлангийн талбай	Тариалангийн газар	Атаршсан газар	
Алтай	269951.5	268824.5	1000.0	69.9		57.1
Алтанцөгц	164481.0	161667.0	2400.0	156.0	223.1	34.9
Баяннуур	159164.0	158293.9	400.0	294.5	114.5	61.1
Бугат	199373.0	198740.0	555.0	24.9	4.1	49.0
Булган	461879.3	461348.7	364.3	99.1		67.2
Буянт	181669.0	181403.1	180.0	22.2	24.4	39.2
Дэлүүн	496165.8	495534.6	524.0	9.0		98.2
Ногооннуур	395953.6	392438.6	3382.0	33.3	66.7	33.0
Сагсай	168402.0	167833.5	400.0	27.1	80.7	60.7
Толбо	283134.0	282684.3	360.0	40.0		49.7
Улаанхус	465310.9	464072.9	1120.0	26.8		91.2
Цэнгэл	264212.0	262932.5	816.0	333.5		130.0
Өлгий						
Дүн	3509696.1	3495773.6	11501.3	1136.3	513.5	771.3

ДҮГНЭЛТ

2019 онд өвөлжилт, малчдын аж байдал өмнөх жилээс харьцангуй сайн байснаас болж мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тооны хувьд оны эхний төллөх насны хээлтэгч малын 94.9 хувь төллөж, 809.2 мянган төл бойжиж, төл бойжилт 93.2 хувьтай гарсан байна. 60425 толгой том мал зүй бусаар хорогдож, оны эхний малын 2.8 хувийг эзэлж байна. Жилийн эцэст 8703 малчин өрх, 13746 малчин, толгойн тоогоор 2 сая 192 мянга 764, бодод шилжүүлснээр 549.1 мянган толгой, үүнээс тэмээ 5913, адуу 99020, үхэр 158582, хонь 995904, ямаа 933345 тоологдсон. Нийт малын 12 хувийг бод, 88 хувийг бог мал эзэлж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 80 гаруй хувийн үйлдвэрлэж, хүн амаа хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах эх үүсвэр болж байгаа бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлж, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанар сайтай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, экспортын нөөцийг нэмэгдүүлэхэд мал аж ахуйн бодлого чухал ач холбогдолтой.

2019 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл үр тариа 24.0 тн, төмс 3535 тн, хүнсний ногоо 1630.5 тн хураасан нь өнгөрсөн оноос төмс 529.8 тн-оор, хүнсний ногоо 106.4 тн-оор их байна.

Газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээхэн нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн уринш боловсруулалтыг нэмэгдүүлэх, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх, иргэдийн дунд тариалалт хийх, ургац хураах зэрэг асуудлаар сургалт, сурталчилгаа явуулж мэдлэгийн дээшлүүлэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Баян-Өлгий аймагт мах, ноосны чиглэлийн казахын ууцан сүүлт керей үүлдрийн хонь, ноолуурын чиглэлийн уулын бор хэмээх үүлдрийн ямаа зэрэг өндөр ашиг шимтэй үүлдрийн болон нутгийн шилдэг омог хэвшлийн мал сүргийг өсгөн үржүүлдэг билээ.

Нутгийн шилдэг омог, үүлдрийн малыг өсгөн үржүүлж, хүрээг нь өргөжүүлэх, малын омог, үүлдэрлэг байдлыг сайжруулах замаар ашиг шимийг нь дээшлүүлэх явдал аймаг, сум, багийн түвшинд бодлого боловсруулагчдын өмнө эрхэм чухал зорилт болгон дэвшүүлэгдэх ёстой.

Нутгийн шилдэг омог, үүлдрийн цөм сүрэг, гадаадын арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах, биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар малын үүлдэрлэг байдлыг сайжруулах.

Мал сүргийг эрүүлжүүлэх, халдварт, паразиттай өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг олон улсын жишигт хүргэж үр дүнг сайжруулах.

Инженерийн болон энгийн уурхайн худаг, уст цэгийг нэмэгдүүлэх, эзэмшил, ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ усны нөөцийн бусад эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, уст цэгүүдийг сэргээн засварлах, шинээр гаргах, цас, борооны усыг хуримтлуулан хиймэл нуур, усан сан, хөв, цөөрөм, бий болгох замаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.

Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэх.

Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг өсгөн үржүүлэх бодлого хэрэгжүүлэх, ялангуяа манай аймгийн нийт малын 50-аад хувийн эзэлдэг ямаан сүргийн тоо, толгойн өсөлтийг хязгаарлах, бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь, 1 ямаа гэсэн харьцаагаар өсгөж

үржүүлэхэд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

МАН-н салбарын хөгжлийн уг язгуур нь сайн үүлдрийн мал үржүүлэх, эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэхээсээ бэлчээрийг эзэмших ашиглах, өмчлөх эрх зүйн тогтолцоо гэдгийг онцолж байна.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

- 1.Баян-Өлгий аймгийн Статистикийн эмхтгэл, 2010-2018 он
- 2.Монгол улсын статистикийн эмхтгэл 2010-2018 он
- 3.Монгол улсын Хөдөө аж ахуй 1971-1995 онд /статистикийн эмхтгэл/
- 5.Хөдөө аж ахуйн салбар, 2011он, ҮСХороо
- 6.Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулга-2010-2019 он,
- 7.Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн салбар, 2012-2016 он
- 8.Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анх дугаар тооллого, 2012 он
- 9.Статистикийн бюллетень 2019/12 сар, ҮСХороо
- 10.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
- 11.Баян-Өлгий аймгийн 2019 оны Мал тооллогын дүн

_____ о О о _____